



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/19

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дахь заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 58 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөрөнгө оруулалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор ажлын тоо хэмжээ, боловсруулах, зураг төслийг хянах, барилга байгууламжийн норм дүрэм стандартыг хангуулах зөвлөх багийн албан хэрэгцээнд зориулан компьютер, техник хэрэгсэл худалдан авахыг зөвшөөрч хавсралтаар баталсугай.

2. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай барилгын техникийн хяналтын зардлаас 8 459 000 төгрөг /Найман сая дөрвөн зуун тавин есөн мянга/ -ийг санхүүжүүлэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021
оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн
А/19 дүгээр захирамжийн хавсралт

ЗӨВЛӨХ БАГИЙН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД КОМПЬЮТЕР,
ТЕХНИК ХЭРЭГСЭЛ ХУДАЛДАН АВАХ ЖАГСААЛТ

№	Компьютер, техник хэрэгслийн нэр	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Процессор /dell 7070 i7 10700 8 gt 1tb dvd rw/	2	2 310 000	4 620 000
2.	Дэлгэц Dell se 2416h	2	385 000	770 000
3.	Принтер Epson l 15150	1	2 769 000	2 769 000
4.	Цахилгаан халаагуур /Тень/	1	170 000	170 000
5.	Интернет роутер	1	130 000	130 000
6.	Нийт дүн	7		8 459 000

-oOo-